



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/95/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мандалговь хот</p> <p>2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70593113 Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Албан шаардлага	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЭМДСНО	Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих нэмэлт орлого
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.02.25 № 42

танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЛХАГВА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ 0012020777

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>37,981,417.36</u>	<u>111,546,543.50</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,308,355.04
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,308,355.04
3121	Төгрөг	-	2,308,355.04
31211	Төрийн сангийн харилцах	-	156,864.34
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	2,151,490.70
33	АВЛАГА	2,833,000.00	69,224,600.48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	0.48
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	66,391,600.00
335	Бусад авлага	2,833,000.00	2,833,000.00
3351	Байгууллагаас авах авлага	2,833,000.00	2,833,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	35,148,417.36	40,013,587.98
351	Түүхий эд материал	17,491,114.91	18,911,012.06
35110	Тусгай зориулалттай материал	4,604,038.56	7,656,836.56
35130	Эм боох материал	12,887,076.35	11,254,175.50
354	Хангамжийн материал	17,657,302.45	21,102,575.92
35410	Бичиг хэргийн материал	1,053,975.00	1,089,700.00
35420	Аж ахуйн материал	14,216,374.00	15,342,083.07
35430	Сэлбэг хэрэгсэл	108,000.00	36,000.00
35440	Түлш, шатах тослох материал	929,000.00	412,100.00
35450	Барилгын засварын материал	652,800.00	3,093,300.00
35460	Хүнсний материал	697,153.45	1,129,392.85
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>489,400,516.87</u>	<u>543,830,098.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	489,400,516.87	543,830,098.94
392	Биет хөрөнгө	483,356,516.87	537,786,098.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	404,255,906.50	404,255,906.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,233,528.31)	(47,758,468.91)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,900,000.00	57,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,593,055.60)	(44,122,222.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,369,303.16	209,436,254.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,370,401.33)	(64,109,536.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,954,706.50	29,925,146.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,926,414.05)	(7,740,981.66)
393	Биет бус хөрөнгө	6,044,000.00	6,044,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,044,000.00	6,044,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>527,381,934.23</u>	<u>655,376,642.44</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,449,836.00</u>	<u>(0.00)</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,449,836.00	(0.00)
413	Өглөг	2,449,836.00	(0.00)
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,449,836.00	(0.00)

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>524,932,098.23</u>	<u>655,376,642.44</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	524,932,098.23	655,376,642.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	386,998,112.66	386,998,112.66
51101	Өмч: - төрийн	386,998,112.66	386,998,112.66
512	Хуримтлагдсан үр дүн	(5,678,366.35)	124,766,177.86
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,678,366.35)	(5,678,366.35)
51220	Тайлант үеийн үр дүн	-	130,444,544.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	143,612,351.92	143,612,351.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>527,381,934.23</u>	<u>655,376,642.44</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	409,524,450.49	782,838,042.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,329,404.49	231,142,702.89
120	Нийтлэг татварын бус орлого	79,329,404.49	231,142,702.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,329,404.49	231,142,702.89
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө		80,928,603.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал		150,214,099.33
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	330,195,046.00	551,695,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	293,667,600.00	353,349,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	293,667,600.00	353,349,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,135,900.00	161,390,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,009,900.00	21,403,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	126,000.00	2,239,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлого		135,248,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,318,000.00	27,508,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,318,000.00	27,508,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,073,546.00	9,446,940.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,073,546.00	9,446,940.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	391,083,685.70	652,393,498.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,083,685.70	652,393,498.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,957,685.70	628,609,144.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,670,931.74	265,948,710.00
210101	Үндсэн цалин	157,083,600.00	149,204,092.00

**Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210102	Нэмэгдэл	59,297,633.74	83,059,937.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,892,000.00	3,109,000.00
210104	Урамшуулал	19,397,698.00	30,575,681.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,932,738.26	34,059,524.00
210201	Тэтгэврийн даатгал	20,051,549.12	23,945,607.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,359,009.12	2,637,044.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,887,207.31	2,097,444.25
210204	Ажилгүйдлийн даатгал	408,920.10	482,937.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,226,052.61	4,896,490.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,967,836.00	20,375,969.65
210301	Гэрэл, цахилгаан	2,576,000.00	2,978,190.85
210302	Түлш, халаалт	15,512,500.00	15,743,312.00
210303	Цэвэр, бохир ус	2,879,336.00	1,654,466.80
2104	Хангамж, бараа материалын зардал	11,624,618.00	23,023,405.38
210401	Бичиг хэрэг	1,490,700.00	2,472,475.00
210402	Тээвэр, шатахуун	7,741,700.00	9,741,160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	584,200.00	984,300.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,650.00	434,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,359,090.00	4,338,600.00
210408	Бараа материал акталсны зардал	355,278.00	5,052,170.00
2105	Нормативт зардал	28,607,985.97	221,280,169.01
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,015,452.92	213,709,269.41
210502	Хоол, хүнс	1,587,533.05	4,458,412.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000.00	3,112,487.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,401,200.00	1,847,800.00
210604	Урсгал засвар	4,401,200.00	1,847,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,207,900.00	1,596,000.00
210702	Дотоод албан томилолт	1,207,900.00	1,596,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,822,315.00	1,379,669.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,376,050.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	220,020.00	247,675.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,705.00	115,254.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	405,000.00	725,000.00
210807	Газрын төлбөр	60,440.00	65,540.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	261,100.00	171,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,722,160.73	59,097,896.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,045,800.00	6,691,975.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	243,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,676,360.73	52,162,121.49
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,000.00	23,784,354.35

2132	Бусад урсгал шилжүүлэг	126,000.00	23,645,560.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,499,960.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,145,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	126,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	138,794.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	138,794.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>18,440,764.79</u>	<u>130,444,544.21</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,317,044.38	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,317,044.38	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,317,044.38)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>12,123,720.41</u>	<u>130,444,544.21</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	386,998,112.66	155,389,692.50	(29,579,427.34)	512,808,377.82
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	11,777,340.58	11,777,340.58
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	386,998,112.66	155,389,692.50	(17,802,086.76)	524,585,718.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(11,777,340.58)	-	(11,777,340.58)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	12,123,720.41	12,123,720.41
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	386,998,112.66	143,612,351.92	(5,678,366.35)	524,932,098.23
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	386,998,112.66	143,612,351.92	(5,678,366.35)	524,932,098.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	386,998,112.66	143,612,351.92	(5,678,366.35)	524,932,098.23
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	130,444,544.21	130,444,544.21
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	386,998,112.66	143,612,351.92	124,766,177.86	655,376,642.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>330,195,046.00</u>	<u>416,447,340.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	330,195,046.00	416,447,340.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	293,667,600.00	353,349,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	293,667,600.00	353,349,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,135,900.00	26,142,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,009,900.00	21,403,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	126,000.00	2,239,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,318,000.00	27,508,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,318,000.00	27,508,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	11,073,546.00	9,446,940.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,073,546.00	9,446,940.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>325,928,046.00</u>	<u>457,332,284.96</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	325,928,046.00	457,332,284.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,802,046.00	433,547,930.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,670,931.74	266,863,796.61
210101	Үндсэн цалин	157,083,600.00	149,204,092.00
210102	Нэмэгдэл	59,297,633.74	83,975,023.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,892,000.00	3,109,000.00
210104	Урамшуулал	19,397,698.00	30,575,681.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,932,738.26	33,144,437.87
210201	Тэтгэврийн даатгал	20,051,549.12	23,030,521.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,359,009.12	2,637,044.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,887,207.31	2,097,444.25
210204	Ажилгүйдлийн даатгал	408,920.10	482,937.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,226,052.61	4,896,490.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,518,000.00	22,825,805.65
210301	Гэрэл, цахилгаан	2,576,000.00	2,978,190.85
210302	Түлш, халаалт	15,512,500.00	15,743,312.00
210303	Цэвэр, бохир ус	429,500.00	4,104,302.80
2104	Хангамж, бараа материалын зардал	12,409,600.00	20,573,070.38
210401	Бичиг хэрэг	1,291,800.00	1,877,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,765,700.00	9,048,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	584,200.00	984,300.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	506,000.00	3,528,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,261,900.00	5,134,410.00
2105	Нормативт зардал	12,787,161.00	72,726,150.30

**Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,194,461.00	65,364,598.30
210502	Хоол, хүнс	979,700.00	4,890,652.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,613,000.00	2,470,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,357,000.00	7,846,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	557,000.00	1,999,200.00
210604	Урсгал засвар	3,800,000.00	5,847,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,207,900.00	1,596,000.00
210702	Дотоод албан томилолт	1,207,900.00	1,596,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,842,915.00	2,251,469.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,209,050.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	220,020.00	247,675.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,705.00	115,254.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	405,000.00	885,000.00
210807	Газрын төлбөр	60,440.00	65,540.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	448,700.00	883,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,075,800.00	5,720,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,075,800.00	5,476,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	243,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,000.00	23,784,354.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,000.00	23,645,560.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	20,499,960.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,145,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	126,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	138,794.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	138,794.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,267,000.00</u>	<u>(40,884,944.96)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,267,000.00	25,663,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,267,000.00	25,663,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,267,000.00	25,663,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,267,000.00	25,663,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4,267,000.00)</u>	<u>(25,663,100.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(66,548,044.96)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,308,355.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн	Үзүүлэлт	Тайлант оны
---------------	----------	-------------

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ангила л		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	402,479,100.00	390,009,181.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,479,100.00	390,009,181.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,329,100.00	386,863,581.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,177,600.00	245,358,611.61
210101	Үндсэн цалин	138,034,900.00	138,034,900.00
210102	Нэмэгдэл	95,776,000.00	83,975,023.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,127,000.00	3,109,000.00
210104	Урамшуулал	20,239,700.00	20,239,688.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,635,100.00	30,462,061.87
210201	Тэтгэврийн даатгал	21,202,200.00	21,202,185.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,424,800.00	2,422,101.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,931,500.00	1,925,489.25
210204	Ажилгүйдлийн даатгал	506,800.00	440,469.78
210205	Эрүүл мэндийн даатгал	4,569,800.00	4,471,816.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,951,100.00	22,825,805.65
210301	Гэрэл, цахилгаан	3,018,800.00	2,978,190.85
210302	Түлш, халаалт	15,827,900.00	15,743,312.00
210303	Цэвэр, бохир ус	4,104,400.00	4,104,302.80
2104	Хангамж, бараа материалын зардал	18,197,700.00	18,184,680.38
210401	Бичиг хэрэг	1,870,900.00	1,863,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,342,800.00	8,341,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	985,300.00	984,300.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,531,700.00	3,528,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,467,000.00	3,466,980.00
2105	Нормативт зардал	31,632,400.00	31,632,352.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,270,800.00	24,270,800.00
210502	Хоол, хүнс	4,890,700.00	4,890,652.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,470,900.00	2,470,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,007,400.00	28,932,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,350,000.00	16,341,600.00
210602	Тавилга	8,100,000.00	8,046,500.00
210604	Урсгал засвар	4,557,400.00	4,543,900.00
2107	Томилот, зочны зардал	1,496,000.00	1,496,000.00
210702	Дотоод албан томилолт	1,496,000.00	1,496,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,255,000.00	2,251,469.80
210803	Даатгалын үйлчилгээ	247,700.00	247,675.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	115,300.00	115,254.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	885,000.00	885,000.00
210807	Газрын төлбөр	69,000.00	65,540.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	883,000.00	883,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,976,800.00	5,720,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,476,800.00	5,476,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	243,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,150,000.00	3,145,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,150,000.00	3,145,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,150,000.00	3,145,600.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	402,479,100.00	390,166,045.65
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	353,349,400.00	353,349,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,349,400.00	353,349,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,508,500.00	27,369,705.65
122005	Орон нутгийн төсвөөс	27,508,500.00	27,369,705.65
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	21,621,200.00	9,446,940.00
122001	Хандив тусламж /дотоод/	21,621,200.00	9,446,940.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	156,864.34

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,847,409.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,847,409.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,347,449.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,505,185.00
210101	Үндсэн цалин	11,169,192.00
210104	Урамшуулал	10,335,993.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,682,376.00
210201	Тэтгэврийн даатгал	1,828,336.00
210202	Тэтгэмжийн даатгал	214,943.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	171,955.00
210204	Ажилгүйдлийн даатгал	42,468.00
210205	Эрүүл мэндийн даатгал	424,674.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,388,390.00
210401	Бичиг хэрэг	14,000.00
210402	Тээвэр, шатахуун	706,960.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,667,430.00
2105	Нормативт зардал	41,093,798.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,093,798.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,577,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,275,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,999,200.00
210604	Урсгал засвар	1,303,500.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,499,960.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	20,499,960.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,499,960.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	94,998,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,998,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,403,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,239,000.00
131106	Эрүүл мэндийн даатгалын нэмэлт орлого	68,856,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	2,151,490.70
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,151,490.70

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төв 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төв нь эрхэм зорилгоо “Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулж иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг стандартын дагуу чанартай түргэн шуурхай хүргэж зонхилон тохиолдох өвчлөлийг эрт илрүүлж эрүүлжүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулан эрүүл аж төрөх дадал хэвшүүлэн дундаж наслалтыг уртасгахад оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Эрүүл мэндийн газрын дотоод хяналт, СТСХ-ийн дотоод хяналт хийгдсэн, зөвлөмж өгөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 650,055.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,750.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,313.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн үр дүнгийн тайланд залруулга хийгдэж нийт зардал 652,393.5 мянган төгрөг болсон. Нийт зардал 652,393.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,785.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатны материаллаг байдлын 75 хувиар буюу 7,339.4 мянган төгрөгөөр дахин шинэчлэн тогтоолоо

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 127,994.7 мянган төгрөгөөр буюу 24.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2,308.4	2,308.4
Авлага	2,833.0	69,224.6	66,391.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	35,148.4	40,013.6	4,865.2
Үндсэн хөрөнгө	489,400.5	543,830.1	54,429.6
Нийт хөрөнгө	527,381.9	655,376.6	127,994.7
Өр төлбөр	2,449.8	-	-2,449.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	524,932.1	655,376.6	130,444.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	527,381.9	655,376.6	127,994.7

Авлагын данс өмнөх оноос 66,391.6 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-аас ковидын зардлын санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой авлагаар тусгасан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 543,830.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 54,429.6 мянган төгрөгөөр өссөн нь УИХ-ын гишүүд, иргэдээс хандив, ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжсэн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авч, 78,183.6 мянган төгрөгийн хөрөнгийг тайланд тусгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 655,376.6 мянган төгрөг болж 130,444.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 533,674.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 533,674.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 131,195.8 мянган төгрөгөөр бууруулан 402,479.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 402,479.1 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 353,349.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 27,508.5 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 21,621.2 мянган төгрөг, нийт 402,479.1 санхүүжилт авахаар батлагдсан байна. Үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас 12,174.3 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авч нийт 390,304.8 мянган төгрөгийн санхүүжилт авснаас урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 99.9 хувийг зарцуулж, 138.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж, 156.9 мянган төгрөгийг харилцахын үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 390,009.2 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын гүйцэтгэл дутуу, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих санхүүжилт дутуу орсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 21,403.5 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 2,500.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн болон нэмэлт үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,239.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалаас санхүүжих нэмэлт орлого 68,856.4 мянган төгрөг, нийт 94,998.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 21,505.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 2,682.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 2,388.4 мянган төгрөг, нормативт зардалд 41,093.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 4,577.7 мянган төгрөг, томилолт зочны зардалд 100.0 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 20,499.9 мянган төгрөг, нийт 92,847.4 мянган төгрөгийг зарцуулж, 2,151.5 мянган төгрөгийг харилцахын үлдэгдлээр тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

1. Ковид-19 цар тахал тархсантай холбоотой тайлант онд тусламж хандив, төсвийн өөрийн хөрөнгөөр нийт 214,962.7 мянган төгрөгөөр эм боох материал, хамгаалах хувцас, хэрэгсэл, эмийн багц, ковидын тест, дархлаажуулалтын вакцин орлого авч, 214,444.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2. Ковид-19 халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн Эрүүл мэндийн газраар дамжуулан хуваарилсан байна. Хуваарилсан эмийн нэг бүрийн үнийг оронгийн цэг, таслалын алдаанаас 10 дахин өсгөж илүү нэхэмжилсэн 90 ширхэг эмийн үнийн зөрүү 1,156.6 мянган төгрөгийн зөрүү, анхан шатны баримтыг ирүүлээгүй тул орлого аваагүй байсан 2,328.4 мянган төгрөгийн эмийг Эрүүл мэндийн газартай тооцоо нийлж, санхүүгийн тайланд тусган залруулга хийсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 515,518.7 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аудит хийгдээгүй санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75,458.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 74,543.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 915.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. ЭМДСНО 68,856.4 мянган төгрөгийг дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан орлогоор тайлагнасан;
2. Мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайлангийн зардлыг 4,600.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
3. Бараа материал акталсан зардал 1,086.8 мянган төгрөгийг нормын хувцас хэрэглэлийн зардлаар тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад нийт 74,543.2 мянган төгрөгийн залруулга хийсэн.

4.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүдэд зөрчлийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлагуудыг хүргүүллээ. Үүнд:

1. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 915.1 мянган төгрөгийг цалингийн зардлаас зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Нийт 915.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1											
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг цалингийн зардлаас зарцуулсан.	1	915.1					1	915.1		
2	ЭМДСНО-ыг дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан орлогоор тайлагнасан	1	68,856.4	1	68,856.4						
3	Мөнгөн гүйлгээний тайлан, үр дүнгийн тайлангийн зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	4,600.0	1	4,600.0						
4	Бараа материал акталсан зардлыг нормын хувцас хэрэглэлийн зардлаар тайлагнасан	1	1,086.8	1	1,086.8						
	Нийт зөрчлийн дүн	7	75,458.3	3.0	74,543.2	-	-	1.0	915.1	-	-